

БАЯНХОНГОР-ЭРЧИМ ХҮЧ” ЦАХИЛГААН ТҮГЭЭХ ХХК-ИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

“Баянхонгор-эрчим хүч” Цахилгаан түгээх ХХК нь анх 1966 онд тэр үеийн Сайд нарын зөвлөлийн тогтоолоор Баянхонгор аймгийн Эрчим хүчний үйлдвэр нэртэй байгуулагдсанаас хойш 2001 онд Төрийн өмчөөс орон нутгийн өмчид шилжүүлэх тухай УИХ-ын 2001 оны тогтоолын дагуу Орон нутгийн өмчид шилжиж ирсэн бөгөөд аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2002 оны 08-р сарын 18-ны өдрийн 78 тоот тогтоолоор “Баянхонгор-Эрчим хүч” Орон нутгийн өмчит ХХК, 2005 оны 5 дугаар сарын 13-нд Төвийн эрчим хүчний системд холбогдсоноор “Баянхонгор-Эрчим хүч” цахилгаан түгээх хязгаарлагдмал хариуцлагатай компани болж өөрчлөгдсөн.

“Баянхонгор-Эрчим хүч” ЦТ ХХК нь **цахилгаан түгээх , цахилгаанаар зохицуулалттай хангах** тусгай зөвшөөрлийг хүрээнд Баянхонгор аймгийн төв болон 13 сум салбарын хэрэглэгчдийг цахилгаан эрчим хүчээр түгээх, хангах үндсэн үйл ажиллагаа явуулж байна.

0.4кВ-35кВ хүртэлх цахилгаан байгууламжийн барилга угсралт, туршилт тохируулгын ажил үйлчилгээ эрхлэх цахилгаан дамжуулах шугам, дэд станцын засвар, угсралт, тоолуур засварлах, суурилуулах, худалдах, баталгаажуулалтад хамрагдсан гүйдлийн трансформатор худалдах, суурилуулах” тусгай зөвшөөрөлтэй.

Компани нь аймгийн орон нутгийн өмчид 100 хувь харъяалагддаг бөгөөд дээд удирдлага Төлөөлөн удирдах зөвлөл нь 11 хүний бүрэлдэхүүнтэй.

Тус компани нь 3 алба нэгжтэй 94 ажилтан албан хаагчтай Захиргаа аж ахуй -25 албан хаагчтай, Цахилгаан шугам сүлжээ шуурхай үйлчилгээний алба-35 албан хаагчтай, Хэрэглэгчдэд үйлчлэх төв-34 албан хаагчтай бүтэц бүрэлдхүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Манай компани нь “Төвийн бүсийн цахилгаан дамжуулах сүлжээ” ТӨХК-ийн Эрдэнэт-Хархорины салбарын “Баянхонгор 110/35/10” дэд станцаас Цахилгаан эрчим хүчийг худалдан авч Баянхонгор аймгийн төв болон ойролцоох Өлзийт, Эрдэнэцогт сумдыг 10 кВ-ын 79.7 км, Шаргалжуут рашаан сувлал тосгон, Заг Гурванбулаг, Жаргалант, сумдын 10 кВ-ын 151,6 км, Баян Овоо, Галуут,

Баацагаан, Хүрээмарал, Баянбулаг сумдыг 15 кВ-ын 347 км, Бөмбөгөр, Бууцагаан, Заг сумдыг 35 кВ-ын 302,3 км Цахилгаан дамжуулах агаарын агаарын шугамаар тэжээж нийт 877,5 км ЦДАШ, 232 дэд станц трансформатораар дамжуулан Аж ахуй нэгж албан байгуулага, Ахуйн хэрэглэгчид нийт 14434 хэрэглэгчдийг тасралтгүй найдвартай цахилгаан эрчим хүчээр ханган аааааа.